

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дэргэдэх

Ёс зүйн дэд хороо

Төрийн албан хаагч нь ёс зүйн зарчим

- ард түмэнд үйлчлэх;
- мэргэшсэн, тогтвортой байх;
- улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;
- Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах;
- төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;
- ил тод байх;
- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- захирах, захирагдах ёсыг баримтлана.

Хүнлэг, энэрэнгүй байх

Хариуцлагатай байх

Хамтач байх

Үнэнч, шударга байх

Манлайлах

Хариуцлагатай байх

Төрийн албан хаагчийн хүлээх нийтлэг үүрэг

- иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх;
- эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах;
- бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх;
- бусдын ажил хэрэгч саналыг үл хайхрах, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;
- бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарлахгүй байх;
- албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;
- албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх.

Төрийн албан хаагчид хориглох үйл ажиллагаа

- төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах;
- удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, оролцох санал тавих;
- хүний эмзэг болон хувийн мэдээллээр бусдыг гутаах;
- албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулах;
- үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох үйлдэл хийх;
- соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах;
- албаны чиг үүрэгтэйгээ холбоогүй хууль зөрчсөн амлалт өгөх;
- албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх.

Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл гаргах:

- Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээллийг энэ хуулийн 14.3-т заасан харьяаллын дагуу Ёс зүйн хороонд, эсхүл Ёс зүйн дэд хороонд гаргана.
- Гомдол, мэдээлэлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, өөрт байгаа бол нотлох баримтыг хавсаргасан байх бөгөөд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.
- Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.

Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх:

- Гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;
- Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;
- Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;
- Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албанаас халах.

Төрийн албан хаагч дараах хэлбэрээр ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно:

- хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйх;
- ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх.

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Ч.Болор-Эрдэнэ, bolorderdene.ch@mddc.gov.mn, тус яамны 202 тоот, утас: 51-266202